



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 6/17

Бор-өндөр сум

**Б.Баярцэцэгийг үйлчлэгчийн ажилд  
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 тоот тогтоолын 6 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 тоот тогтоолын 11 дүгээр хавсралт, 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

4. Батхуягийн Баярцэцэгийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн үйлчлэгчээр томилон ажиллуулсугай.

5. Б.Баярцэцэгийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн ТҮ1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 954.000 (есөн зуун тавин дөрвөн мянга), Орон нутаг ажилласны нэмэгдэл цалингийн 40% 381.000 (гурван зуун наян нэгэн мянга), хоолны мөнгө өдрийн 10.000 (арван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.

6. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Б.Баярцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА  А. БАТБААТАР

